



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

12
АНГИ

НИЙГЭМ СУДЛАЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

7. Соёлын хожимдол гэсэн ойлголт аль нь вэ?
- A. Тодорхой цаг үед нийгмийн гишүүдийн дийлэнхийн амьдрах зан үйл үйлдлийг тодорхойлогч соёл
 - B. Нийгэмд зонхилогч соёл оршин байхын зэрэгцээ нийгмийн бүлгүүд харилцан адилгүй өөрийн соёлыг бий болгоно
 - C. Материаллаг амьдралын өөрчлөлтүүд нь зан заншил, итгэл үнэмшлийн өөрчлөлтөөс түрүүлж байж болно
 - D. Булаан эзлэх, шашин дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийн нөлөө зэрэг олон сувгуудаар соёлын үнэт зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц

8. Хүснэгтийн хоосон зайд тохирох өгөгдлийг зөв байршуулна уу.
 Өгөгдөл: /1-Соёлын орон зай; 2-Соёлын аялал жуулчлал; 3-Соёлын даяаршил; 4-Соёлын шок; 5-Соёлын дархлаа; 6-Соёлын адилсал/

a.....	Соёлынх нь өвөрмөц байдал болон бусдаас ялгаран онцгойрох хэв маягт гаднын нөлөө орж өөрчлөгдөх, эсвэл соёлын тулгалтаар устгах оролдлого гарах тохиолдол бүрд хариу үзүүлэх чадвар
b.....	Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү соёлын байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдал
c.....	Өөр соёлын орчин нөхцөл тухайн хүний хүссэнээс огт өөр байх, бүтэлгүйтэх, сэтгэл ханамж мэдрэгдэхгүй байх үед үүсэх бухимдал, гутрал, түгшүүр гэх мэт сөрөг мэдрэмж үүсэх үеийн сэтгэл зүйн байдал

- A. a5,b6,c4 B. a6,b5,c4 C. a1,b3,c4 D. a3,b1,c4

9. Макро эдийн засгийн судлах зүйлээс илүүцийг олно уу.
- A. мөнгө, зээлийн асуудал
 - B. ажил эрхлэлтийн түвшин
 - C. үйлдвэрлэлийн үр ашгийн үзүүлэлт
 - D. эдийн засгийн өсөлт
10. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.
 Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг гэсэн дүгнэлт хийж, ингэж олсон ашгийг Маркс “.....” гэж нэрлэсэн.
- A. Нэмүү өртөг
 - B. Туйлын давуу тал
 - C. Харьцангуй давуу тал
 - D. Хувьсгал ба өөрчлөлт
11. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.
 Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээг гэнэ.
- A. эрэлт
 - B. хоёрдогч хэрэгцээ
 - C. нийлүүлэлт
 - D. эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйл
12. Дараах ойлголтуудаас нь аль нь хүний хөгжлийн индекс вэ?
- A. Насжилт, нялхсын эндэгдэл, бичиг үсэгт тайлагдсан байдал
 - B. Дундаж наслалт, боловсролын түвшин, нялхсын эндэгдэл
 - C. Дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ноогдох ДНБ
 - D. Насжилт, нялхсын эндэгдэл, нэг хүнд ноогдох ДНБ

13. Хүснэгтэд байгаа ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Орлогыг бий болгох чадвартай бүхий л зүйл / <i>тоног төхөөрөмж, барилга</i> /	1	Газар
b	Байгалийн нөөц/ <i>усны хүч, нарны эрчим хүч</i> /, газрын баялаг/ <i>газрын тос, нүүрс, төмрийн хүдэр</i> /	2	Капитал
c	Материаллаг болон оюуны үнэт зүйлсийг бий болгоход чиглэгдсэн, тодорхой зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа	3	Хөдөлмөр

- A. a3,b1,c2 B. a2,b1,c3 C. a1,b3,c2 D. a3,b2,c1

14. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.

..... гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүд үр дагаврыг бий болгох байдлаар харилцан тохиролцож хийсэн бичвэрийг хэлнэ.

- A. Гэрээ B. Хэлцэл C. Нэхэмжлэл D. Гэрээ байгуулах санал

15. Хүний эрхэм чанарын үндсэн шинжид аль нь хамаарахгүй вэ?

- A. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг
B. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл
C. Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болдоггүй
D. Хүний эрхэм чанар нь хэмжигдэх үнэт зүйл

16. Хүний эрхийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага аль нь вэ?

- A. Улсын Их Хурал B. Шүүх C. Засгийн газар D. Үндсэн хуулийн цэц

17. Давж заалдах гомдол гаргасан хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авснаас хойш хэд хоногийн дотор хянан шийдвэрлэх вэ?

- A. 7 хоног B. 14 хоног C. 21 хоног D. 30 хоног

18. Хүснэгтэд байгаа ойлголтуудыг зөв тохируулна уу.

a	Эрх зүйн зөрчлийн улмаас шууд бий болсон үр дагавар	1	Гэм хор
b	Хохирлын улмаас бий болсон үр дагавар	2	Хор уршиг
c	Хохирол, хор уршгийг багтаасан ойлголт	3	Хохирол

- A. a1,b3,c2 B. a1,b2,c3 C. a2,b3,c1 D. a3,b2,c1

19. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.

..... гэдэг бол нийгмийн олон түвшинд шийдвэр гаргах, түүнд нөлөөлөх, эрх мэдлийг олж авах, түүний төлөө тэмцэлдэх, эрх мэдэлд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг үйл явц юм.

- A. Улс төр C. Улс төрийн засаглал
B. Улс төрийн дэглэм D. Улс төрийн шийдвэр

20. “Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрдөг” гэсэн зарчмыг мөрддөг дэглэм аль нь вэ?

- A. консерватив дэглэм C. либераль дэглэм
B. тоталитар дэглэм D. охлократ дэглэм

21. Олон намын системтэй улс орнууд аль нь вэ?

- А. Англи, АНУ, Япон
 В. Франц, Герман, Монгол
 С. Куба, Хойд Солонгос, Хятад
 D. Куба, АНУ, Хятад

22. Хүснэгтэд байгаа ойлголтуудыг зөв тохируулна уу.

a	Нийгэм дэх байгууллага, бүлэглэлүүдийн нөлөөлөл нь улс төрийн засаглалыг харилцан тэнцвэртэй байлгахад чиглэдэг.	1	Сонгодог ардчиллын онол
b	Нийгэм олон янзын сонирхол бүхий бүлэг, давхраанаас бүрдэх тул бусдаас давуу шинжээрээ тодорч ялгарсан цөөнх төр засгийг удирдана гэж үздэг.	2	Элитийн ардчиллын онол
c	Иргэдийн ухамсартай оролцоогоор байгуулагдсан төр, засаг ард түмний өмнө бүрэн хариуцлага хүлээх ёстой гэж үздэг.	3	Олон ургалч ардчиллын онол

- A. a2,b3,c1
 B. a1,b3,c2
 C. a3,b2,c1
 D. a1,b2,c3

23. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээг гэж ангилдаг.

- А. хувийн болон нийтийн
 В. бичигдмэл ба бичигдмэл бус
 С. албан ба албан бус
 D. диспозитив ба императив

24. Цэгийн оронд тохирох оныг сонгоно уу.

Европын холбоо нь 1957 онд Ромын гэрээгээр байгуулагдсан бөгөөд эхний үед Европын Эдийн Засгийн Хамтын Нийгэмлэг-ЕЭЗХН нэрээр нэрлэгдэж байгаад оноос Европын Холбоо гэж нэрлэгдэх болжээ.

- А. 1957 он
 В. 1967 он
 С. 1989 он
 D. 1994 он

25. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудыг зөв тохируулна уу.

Өгөөдөл: /1-ILO; 2-UNDP; 3-WORLD BANK; 4-UNICEF; 5-UNFPA; 6-WHO; 7-UNESCO; 8-UNHCHR /

a.....	НҮБ-ын Хүүхдийн сан
b.....	НҮБ-ын Хүн Амын Сан
c.....	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр

- A. a5,b4,c2
 B. a4,b5,c2
 C. a6,b8,c1
 D. a8,b6,c1

САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1; 2.2; 2.3) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу зөв хариултыг будаарай.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 Хүснэгтэд байгаа дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Эрх зүйт төр	1	Төрийн зохион байгуулалт, удирдлага түүнийг хэрэгжүүлэх арга
b	Социал төр	2	Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанар буюу төр, иргэний нийгэм хоёр хууль эрх зүйн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга загвар
c	Төрийн хэлбэр	3	Тухайн орон нутаг дэвсгэр, засаг захиргааны бүтэц, нэгжийн хууль зүйн статус, төрийн төв болон орон нутгийн байгууллагын хоорондын харилцааны журам
d	Төрийн байгууламж	4	Албадлагын өвөрмөц аппаратад тулгуурлаж, бүх ард нийтэд хүрч байх улс төрийн засаглалын төвлөрсөн хэлбэр
e	Төрийн засаглал	5	Хүмүүсийн амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн нийгмийн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маяг

2.2 Хүснэгтэд байгаа дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Баруун нам	1	Хатуу гишүүнчлэлтэй. Сонгуулийн бус үеэр ч үйл ажиллагаагаа явуулдаг
b	Зүүний нам	2	Намын хэргийг намын элит буюу лидерүүд нь хариуцан хэрэгжүүлдэг
c	Кокус нам	3	Төрийн нийгмийн бодлогыг хязгаарлахыг эрмэлзэлдэг. Бизнес эрхлэгч, хувийн өмчтөн, дунд ангийнхныг дэмждэг
d	Боловсон хүчний нам	4	Төрийн нийгмийн бодлогыг явуулах эрмэлзэлтэй. Доод хэсгийнхэн буюу ядуу хэсгийг ч дэмждэг
e	Олон түмний нам	5	Хатуу гишүүнчлэлгүй. Сонгуулийн үеэр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг

2.3 Улс бус оролцогчдыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу.

a	Олон улсын байгууллага	1	Католик сүм
b	Олон улсын төрийн бус байгууллага	2	Эмнэсти Интернэйшнл
c	Шашны байгууллага	3	Ромын пап, Билл Гейтс
d	Нөлөө бүхий хувь хүн	4	НҮБ тэргүүтэй олон улсын байгууллага
e	Үндэстэн дамнасан корпорацууд	5	CocaCola, CU